

**БУЛГАН АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ 08 ДУГААР САРЫН МЭДЭЭ**

Нэг. Удирдлага зохион байгуулалтын талаар:

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны талаар:

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлыг хоёр удаа хийж, 7 асуудал хэлэлцэн, 8 тогтоол гаргалаа.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын ирц 63,63-90,9 хувь байлаа.

Аймгийн ИТХ-ын ээлжит 9-р хурлаар Булган аймгийн ИТХ-ын долоо дахь удаагийн сонгуулийн ээлжит XV хуралдааныг Булган суманд хуралдуулахаар шийдвэрлэлээ.

Булган аймгийн ИТХ-ын 2016-2020 онд баримтлан ажиллах үйл ажиллагааны чиглэлийн хэрэгжилт, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны “Хөгжлийн хөтөч” хөтөлбөрийн хэрэгжилт, төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2019 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлангийн дүнгийн тухай, аймгийн 2020 оны төсөвт тодотгол хийх, аймгийн эдийн засаг, нийгмийг 2020-2024 онд хөгжүүлэх чиглэлд санал өгөх тухай зэрэг асуудал хэлэлцэхээр төлөвлөв.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн аймгийн сонгуулийн хороо байгууллаа. Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын аймгийн сонгуулийн хорооны даргаар аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга Д.Батчулуун, нарийн бичгийн даргаар ИТХ-ын хуулийн зөвлөх Д.Алтаншагай, гишүүдээр аймгийн ЗДТГ-ын дарга, зарим хэлтэс, агентлагийн дарга, мэргэжилтнүүд ажиллах юм.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 10-р хурлаар аймгийн ИТХ-ын долоо дахь удаагийн сонгуулийн XV хуралдааны товыг хойшлуулж 9-р сарын 18-ны өдөр хуралдуудахаар шийдвэрлэсний дээр “Авто зам, төмөр замын ажилд ашиглах түгээмэл тархацтай ашигт малтмалын борлуулалтын үнэлгээг тогтоох тухай” асуудлыг нэмж хэлэлцэхээр шийдвэрлэлээ.

Төрийн захиргааны чиглэлээр

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны “Хөгжлийн хөтөч” хөтөлбөрийн 70 зорилт, 379 арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулав. Хөтөлбөрийн хэрэгжилт 2016-2020 оны өссөн дүнгээр 92.2 хувьтай байна.

Мөн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс гаргасан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж байна.

Жендэрийн үндэсний хорооноос 08 дугаар сарын 27-28-ны өдрүүдэд зохион байгуулсан "Оролцооны хяналт-шинжилгээ, үнэлгээ болон мэдээлэл харилцааны чадавх бэхжүүлэх" хангайн бүсийн аймгуудын сургалтад хамрагдсан.

Энэ сард ЗГ-ын 1 тогтоол ирснийг хяналтад авч, аймгийн Засаг даргын зөвлөлийн гишүүдэд танилцуулав.

Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд:

Аймгийн байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй Баян-Агт сумын Хануй ангархайн замын засвар, шинэчлэлийн ажилд 28.2 сая, Ойн хортны тэмцлийн ажилд 70.0 сая, Ойжуулалтын ажилд 31.8 сая, Ой бүхий сумдад ойн хортны судалгааны ажилд 14.9 сая, Усны тоо бүртгэлийн ажилд 6.4 сая, Булган сумын Майдарын голын эргийн хамгаалалт болон Диваажин сүмийн орчмын тохижилтын ажлын зураг төсөл, судалгааны ажилд 1.5 сая, Булган сумын ус дулаан дамжуулах төвийн тоног төхөөрөмжийн өргөтгөл, шинэчлэлийн ажилд 46.0 сая, АЗДТГ-ын лед дэлгэц худалдан авах ажилд 10.0 сая, Тэшигийн Буриад зоны өв соёлын судалгааны ажилд 10.0 сая, Рашаант сумын хог хаягдлын цэгийг дарж булах, хашаажуулах, шилжүүлэх ажилд 8.4 сая, Булган аймгийн газар нутгийг илэрхийлсэн самбар хийж, хил орчмын бүсүүдэд байршуулах ажилд 29.1 сая, Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдийн хүрээнд хийгдсэн эссэ бичлэгийн уралдааны зардалд 1.0 сая, нийт 257.8 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар аж ахуй нэгж, байгууллагын ирцийн мэдээг 05 дугаар сарын 20-ны өдрийн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлсэн.

Сангийн яамнаас зохион байгуулсан "Төрийн албан хаагчийн цалингийн нэгдсэн систем"-ын онлайн сургалтад амжилттай хамрагдаж 7 сургагч багш бэлтгэсэн. Үүнтэй холбоотойгоор 16 сум 1 тосгоны "Төрийн албан хаагчийн цалингийн нэгдсэн систем"-ын сургалтыг зохион байгуулсан.

Суманд 602.6 сая, орон нутгийн төсвийн байгууллагуудад 1466.1 сая, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудад 3318.6 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон.

Улсын төсөвт 302.9 сая, аймгийн төсөвт 7359.8 сая төгрөг, сумын төсөвт 35.3 сая төгрөг төвлөрүүлж орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 100 хувьтай байна.

Орон нутгийн өмчит байгууллагуудаас хөрөнгийн хөдөлгөөн хийлгүүлэхээр ирүүлсэн материалуудыг 05 дугаар сарын 20-ны өдрийн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлсэн.

Гурав: Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

Хууль зүйн сайдын эрхлэх хүрээний агентлагууд болон аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх, зүйн хэлтсээс 2020 оны 08 дугаар сард дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Нэг баг-Нэг агт аяны хүрээнд Бугат, Бүрэгхангай, Рашаант, Сайхан сумдаас нийт 9 актыг гаргуулах болсон.

Нутгийн захиргааны байгууллагад эрх зүйн туслалцаа үзүүлэх ажлын хүрээнд 8 дугаар сард 2 сумын Засаг даргын 87 захирамж, 23 тушаалын эрх зүйн үндэслэлийг хянаж, зөвлөмж чиглэл хүргүүлэн ажиллалаа.

Бусад байгууллагаас ирүүлсэн 2 албан бичгийн дагуу байгууллагынхаа ажилчдад зар мэдээг хүргэсэн.

Иргэдийн хууль ёсны эрхийг хамгаалах, хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх зорилтын хүрээнд аймгийн Хууль зүйн туслалцааны төвөөр 12 иргэн үйлчлүүлж хуулийн зөвлөгөө, өмгөөллийн үйлчилгээг авсан байна.

Аймгийн хэмжээнд 2020 оны 8 дугаар сард бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлыг танилцуулахад 268 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 53 хэргээр буюу 16,6 хувиар буурсан. Илрүүлэлтийн хувь 46 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 4,2 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Сайхан, Сэлэнгэ, Хялганат, Бүрэгхангай, Хангал, сумдад урьд оны мөн үеэс өсч, Гурванбулаг, Баяннуур, Орхон, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр, Тэшиг, Бугат, Дашинчилэн, Рашаант Баян-Агт, Булган сумдад урьд оны мөн үеэс буурсан байна. Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн тухайд 57 бүртгэгдэж 21 хэргээр буюу 36,9 хувиар өссөн үзүүлэлттэй.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажлын чиглэлээр 8 дугаар сард хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ 2, хорихоос өөр төрлийн ял шийтгэл эдэлсэн иргэдээс торгох ялын 32 гүйцэтгэх хуудасны 100 158 400 төгрөгийн үлдэгдэлтэй, нийтэд тустай ажил хийлгэх ялын 4 гүйцэтгэх хуудасны 832 цагийн үлдэгдэлтэй, эрх хасах ялын 14 гүйцэтгэх хуудасны 6482 хоногийн үлдэгдэлтэй байна. Албадлагын арга хэмжээ авсан тэнссэн 57 иргэн түүнээс хугацааны өмнө тэнсэн суллагдсан 17, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авсан 6, хөрөнгө орлого хураах 26 гүйцэтгэх хуудасны үлдэгдэл 114 675 500 төгрөг, шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан 1 иргэн байна.

Шүүх шинжилгээний албан чиглэлээр нийт 31 хэргийн газрын үзлэгт мэргэжилтнээр оролцож хулгайн 8, зам тээврийн ослын 6, хүний амь нас хохирсон 10, бусад 7 хэргийн газрын үзлэгт оролцон 862 кадр гэрэл зургаар ул мөр бэхжүүлсэн. Илрүүлсэн гарын мөр 7, гутлын мөр 5, тээврийн хэрэгслийн мөр 18, бичил мөр 1, эвдлэгч багаж 2, биологийн гаралтай ул мөр 3 бусад ул мөр, эд мөрийн баримт 7-г илрүүлж, ажилласан байна. Эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр кримналистикийн 3, шүүх эмнэлгийн шинжилгээнд 10, цогцост 10, Задлан 9 гэмтлийн зэрэг тогтоох 38, билгийн холбогдолтой 3, химийн шинжилгээ 25 хийж, халуун мөрөөр эзэн холбогдогчийг тогтоосон 2, шинжилгээгээр нотолсон эзэнгүй хэрэг

1 нийт 76 үзлэг шинжилгээ хийж, шинжээчийн дүгнэлтийг хугацаанд нь гарган ажилласан.

Архивын тасгийн чиглэлээр:

Лавлагаа авахыг хүссэн 101 иргэнд 526 баримтаар үйлчилсэн. Тушаалын 261, малын А дансны 19, цалингийн 246 баримт гарган үйлчилсэн. Үүнээс 59 иргэнд цалингийн цэсний лавлагаа, 80 иргэнд хуулбарын лавлагаа олгосон.

Цахимд оруулсан Рашаант сумын 1985-2011 оны 170 баримт, Гурванбулаг сумын 1973-2003 оны 82 баримт, Орхон сумын Өлзийт хорооны 1989-1998 оны 53 баримтыг бүртгэлтэй нь тулган хүлээн авч, баталгааны хуудсанд бичилт хийж тавиур дээр байрлуулсан.

Аймгийн Ардын боловсролын хэлтсийн 1942-1972 оны 22 баримтын 2089 хуудсыг нягтлан шалгав.

Барилга байгууламж ашиглалтад оруулах дүрмийн дагуу аймгийн Нэгдсэн эмнэлгийн Ариутгалын тасгийн засвар, Бугат сумын Түлүүгийн давааны хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн борлуулах цэгийг ашиглалтад хүлээн авах улсын комисст орж ажилласан.

15 хөмрөгийн 1939-1991 он 948 баримтад тооллого хийж бүртгэлийг шинээр үйлдлээ.

Үндэсний хөтөлбөрийн хүрээнд:

1.Рашаант сумын Сургуулийн 1988-1999 оны 12 хн-ийн 1069 хуудас, Гурванбулаг сумын 1973-2003 оны 58 баримтын 2886 хуудас, Орхон сумын Өлзийт хорооны 1989-1998 оны 34 баримтын 781 хуудас, нийт 3 хөмрөгийн 104 баримтын 4736 хуудсыг программд тодорхойлон бичсэн.

**Дөрөв: Боловсрол, соёл, эрүүл мэнд,
нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:**

Боловсролын чиглэлээр:

Багшийн мэргэжлийн сул орон тоонд сонгон шалгаруулалт зохион байгуулсан тухай

Булган аймгийн Засаг даргын 2019 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн А/363 дугаар захирамжийн дагуу 2020-2021 оны хичээлийн жилд ажиллах багшийн сул орон тоонд сонгон шалгаруулах “Батламж” шалгалтыг 2020.08.13-д зохион байгуулж 101 хүн хамрагдсанаас 49 тэнцэж, одоогоор 22 багш ажлын байраар хангагдлаа.

Сургалт семинар

Булган аймгийн ЕБС-ийн захирал, сургалтын менежер, цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, насан туршын боловсролын мэргэжилтэн, Боловсрол, соёл, урлагийн ажилтан нийт 63 хүнд 2019-2020 оны хичээлийн жилийн зорилтын биелэлт, 2021-2022 оны хичээлийн жилд хэрэгжүүлэх ажлын талаар 2020.08.23-аас хоёр өдрийн сургалт зохион байгууллаа. Тус сургалтаар онцгой байдлын нөхцөлд хичээл сургалтын үйл

ажиллагааг хэрхэн зохион байгуулах, боловсролын салбарт шинээр гарсан эрх зүйн актууд, хичээл бүрээр 2021-2022 оны хичээлийн жилд дэвшүүлж буй бодлого чиглэл, Мэргэжлийн хяналтын газрын мэдээлэл, Эрүүл мэндийн газрын мэдээлэл зэргийг өгч, шинэ хичээлийн жилд хийх ажлын аймгийн нэгдсэн төлөвлөгөөг гаргалаа.

Биологи, мэдээлэл харилцааны технологи, газарзүй, Орос хэл, англи хэл, сургуулийн өмнөх боловсрол, бага боловсрол, Монгол хэл, уран зохиол, үндэсний бичиг, түүх, нийгмийн ухаан, хими, технологи, физик, математик, биеийн тамир, хөгжим гэсэн 15 хичээлийн 221 багшийг “Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх нь” сэдэвт орон нутгийн сургагч багш бэлтгэх цахим сургалтыг 2020.08.26-27-д зохион байгуулж, хичээл сургалтын үйл ажиллагааг хэвийн явуулах арга зүйд сургаж байна.

Хөрөнгө оруулалтын чиглэлээр хийсэн ажил

Булган аймгийн сургуулийн өмнөх боловсролын 44, ерөнхий боловсролын сургуулийн 40 нийт 84 багшийг зөөврийн компьютероор, 5 сургуулийг ухаалаг самбараар хангаж, сургалтын орчны техник хэрэгслийг нэмэгдүүллээ.

Дөрөв. Элсэлтийн ерөнхий шалгалтын дүн мэдээнд боловсруулалт хийсэн тухай Булган аймгийн Боловсролын газрын мэргэжилтнүүд 10 судлагдахуунаар 2020 онд Элсэлтийн ерөнхий шалгалт өгсөн дүн, 2019-2020 оны хичээлийн жилд Боловсролын газраас авсан сорилгын дүнгийн агуулга, даалгаврын гүйцэтгэл, сургуулиудын эзэлсэн байр, суралцагчдыг амжилттай бэлтгэсэн багш нар, анхны онооны дунджаар нь эрэмбэлэн боловсруулалт хийсэн үр дүнг семинарт мэдээлэл хийж, цаашид анхны онооны дундаж бага судлагдахууныг хэрхэн сайжруулах талаар чиглэл өгсөн. Улсын дунджаас доогуур үнэлэгдсэн хичээлүүдийн анхны онооны дунджийг энэ оноос 5 функтээр ахиулах зорилт дэвшүүллээ.

Эрүүл мэндийн чиглэлээр:

Эрүүл мэндийн газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар Эрүүл мэндийн байгууллагуудын 2019 оны үйл ажиллагааны үр дүнг шалгуур үзүүлэлтээр дүгнэн, салбарын шилдгүүдийг тодрууллаа. Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны зөвлөгөөнийг 2020 оны 8 дугаар сар 15-ны өдөр цахимаар зохион байгуулж, “Оны шилдэг байгууллага”-аар 1-р байранд Сэлэнгэ сумын Эрүүл мэндийн төв, 2-р байранд Сайхан сумын Эрүүл мэндийн төв, 3-р байранд Хялганат тосгоны Эрүүл мэндийн төв тус тус тодорсон.

“Оны шилдэг ажилтан”-аар:

1. Аймгийн Эрүүл мэндийн салбарын “2019 оны шилдэг менежер”- Сайхан. Сумын Эрүүл мэндийн төвийн дарга Б.Дулам
2. Аймгийн Эрүүл мэндийн салбарын “2019 оны шилдэг их эмч” –Аймгийн Нэгдсэн эмнэлгийн нярайн их эмч П.Оюун-Эрдэнэ
3. Аймгийн Эрүүл мэндийн салбарын “2019 оны шилдэг залуу их эмч”-Сэлэнгэ сумын Эрүүл мэндийн төвийн их эмч Б.Оргил

4. Аймгийн Эрүүл мэндийн салбарын “2019 оны шилдэг эм зүйч”-Булган эм импекс ХХК-ийн захирал Г.Батцэцэг

5. Аймгийн Эрүүл мэндийн салбарын “2019 оны шилдэг сувилагч”-Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Мэс заслын тасгийн хагалгааны сувилагч С.Уранчимэг

6. Аймгийн Эрүүл мэндийн салбарын “2019 оны шилдэг бага эмч”-Хангал сумын Эрүүл мэндийн төвийн багийн бага эмч М.Мөнгөнцэцэг

7. Аймгийн Эрүүл мэндийн салбарын “2019 оны шилдэг нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн”-Баян-Агт сумын Эрүүл мэндийн төвийн арга зүйч бага эмч

8. Аймгийн Эрүүл мэндийн салбарын “2019 оны үйлчилгээний шилдэг ажилтан”-Эрүүл мэндийн газрын ариутгагч Г.Оюунцэцэг

9. “Алтан чагнуурын эзэн”-Дашинчилэн сумын Эрүүл мэндийн төвийн дарга М.Соёлмаа

Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ:

Өрхийн эмч нарыг чадавхжуулах "Ухаалаг гэр бүл төлөвлөлт - Эрүүл өрх гэрийн үндэс" сэдэвт төвийн бүсийн уулзалт, сургалтыг 8-р сарын 19-ны өдөр МӨАУМХ, АШУҮИС-ын Өрхийн анагаах ухааны тэнхимтэй хамтран амжилттай зохион байгууллаа. Уулзалт, сургалтад Орхон, Булган аймгийн ЭМТ-үүдийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн нийт 70 хүн оролцсон.

“Эрүүл мэндийн тухай” хуулийн 8.1.24 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/420 дугаар тушаалыг баримтлан, цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан Эрүүл мэндийн сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайдын хамтран баталсан удирдамжаар боловсролын байгууллагад ажиллаж буй нийт төрийн албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх багцын үзлэгт хамруулах талаар удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас зарласан сонгон шалгаруулалтад тэнцсэн аймгийн Нэгдсэн эмнэлэг, Хутаг-Өндөр, Хишиг-Өндөр сумдын Эрүүл мэндийн төвд багцын үзлэгийг зохион байгуулж байна.

Глобал сангийн ДОХ, сүрьеэгийн төслийн төлөөлөгч, ЭМГ-ын дарга, мэргэжилтнүүд, аймгийн НЭ-ийн дарга, сүрьеэгийн тасгийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдтэй хамтарсан уулзалт хурал хийж, уулзалтаар сүрьеэгийн тусламж үйлчилгээний өнөөгийн байдал, илрүүлэг үзлэгийг орон нутагт зохион байгуулах талаар хэлэлцлээ.

Эрүүл мэндийн байгууллагууд:

- 430 зөвлөгөө зөвлөмж, мэдээллийг цахим хуудсанд байршуулж
- 7850 иргэн татаж авсан
- 8600 иргэнд мэдээлэл таалагдсан
- 137 иргэн эерэг сэтгэгдэл бичсэн
- 11120 иргэн үзсэн байна.

Эмнэлгийн тусламж үйлчилгээ үйлчилгээ:

Өндөржүүлсэн бэлэн байдлын үеийн долоо хоног тутмын ажлын тайланг Эрүүл мэндийн байгууллагуудаас авч нэгтгэн, ЭМЯ-ны эмнэлгийн тусламжийн хэлтэст хүргүүлсэн.

“Эх баригч нарын мэргэжлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх нь” сэдэвт сургалтыг ЭМГ-ын сургалтын танхимд 2 өдөр зохион байгуулж, нийт 26 эх баригч нар хамрагдан, мэргэжлийн мэдлэг ур чадварыг сайжрууллаа.

“Ахлах сувилагч нарын удирдлага, манлайллын нэмэгдүүлэх нь” сэдэвт сургалтыг 8-р сарын 24-25-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа. Сургалтад сувилгааны албаны дарга, ахлах сувилагч нийт 22 мэргэжилтэн хамрагдсан ба АШУУИС-ийн захирлын 2020 оны А/101 тоот тушаалаар “Сувилахуйн удирдлага манлайлал” чиглэлээр мэргэжил дээшлүүлсэн сувилагч нарт гэрчилгээ гардуулав.

Эрүүл мэндийн байгууллага, Булган сумын эм сан, эм хангамжийн байгууллагуудын нөөцийн судалгааг нэгтгэн ЭМЯ-нд цахим хаягаар хүргүүлсэн

Биеийн тамир спортын чиглэлээр:

“Бяцхан тамирчин” хөтөлбөрийн хүрээнд Монголын тусгай олимпийн хороо, Булган аймгийн салбар хорооноос хамтарсан сургалтыг аймгийн Засаг даргын ивээл дор зохион байгуулж байна. Тус сургалтанд аймаг сумын цэцэрлэгийн багш, эцэг эх, сурган хүмүүжүүлэгчид хамрагдлаа.

Нийгмийн халамжийн чиглэлээр:

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр:

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд 2020 оны 8-р сарын байдлаар 1982 иргэн ажил хайгчаар бүртгэлтэй байгаагаас шинээр 43 иргэн идэвхтэй ажил хайгчаар бүртгүүлсэн байна. Ажилгүйдлийн тэтгэмжийн тодорхойлолтыг нийт 9 иргэнд гарган Нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлэв.

Ажил олгогч 6 байгууллагаас 9 ажлын байрны захиалга авч, орон нутгийн телевиз болон зарын цэгүүдээр байршуулан зар сурталчилгааг явуулж ажиллалаа.

Шинэ ажлын байр: Шинээр бий болж байгаа ажлын байранд 24 иргэн орж ажилласнаас байнгын ажлын байранд 2 иргэн, улирлын ажлын байранд 9 иргэн, түр ажлын байранд 13 иргэн тус тус ажлын байранд зуучлагдан ажиллаж байна.

Ажилд зуучлагдсан иргэн: Ажил олгогч иргэн, аж ахуйн нэгж байгууллагын сул чөлөөтэй ажлын байранд 21 иргэн ажлын байранд зуучлагдсанаас байнгын ажлын байранд 3 иргэн, улирлын ажлын байранд 8 иргэн, түр ажлын байранд 10 иргэн тус тус зуучлагдан ажиллаж байна.

Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох ганцаарчилсан зөвлөгөөг 4 иргэнд өгч, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн санд бүртгэлжүүлэв. Өссөн дүнгээр ганцаарчилсан зөвлөгөөг 305 иргэнд үзүүлсэн байна.

Нийгмийн халамжийн чиглэлээр:

Үзүүлэлт	Хүний тоо	Өртөг /мян.төг/
Халамжийн тэтгэвэр	1130	1586857,5
Халамжийн тэтгэмж	2684	859808,1
Ахмад настанг асарч буй иргэнд НМТ	972	515918,2
ХБ-тэй иргэнийг асарч буй иргэнд НМТ	358	182569,1
Байнгын асаргаатай ХБ-тэй хүүхэд НМТ	191	148628,8
Бүтэн өнчин хүүхэд үрчлэн авч өсгөсөн тэтгэмж	26	12692,0
Ахмад настанд үзүүлсэн тусламж/хөнгөлөлт	1044	122662,2
ХБ-тэй иргэнд үзүүлсэн тусламж/хөнгөлөлт	234	39028,5
Амьжиргаа дэмжих сангаас олгосон/тусламж	1435	416220,1
Алдарт эхийн одон	5505	705100,0
Хүнс тэжээл хөтөлбөр	4530	475888,0
Алдар цолтой ахмад	29	32000,0
Цалинтай ээж	681	129316,5

Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд:

Мал аж ахуйн талаар :

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Хөдөө аж ахуйн салбарын 2020-2021 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” 19 дугаар тогтоол, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн “Мал аж ахуйн өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг хангах нэгдсэн төлөвлөгөө батлах тухай” 37 дугаар тогтоол, Аймгийн Онцгой комиссын 2020 оны “Мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл ажлыг эрчимжүүлэх тухай” албан даалгавар зэргийг сумдад хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Ялангуяа мал аж ахуйн өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах нэгдсэн төлөвлөгөөний дагуу нийт суманд хадлан, тэжээл бэлтгэлийн ажлыг чанартай, шуурхай зохион байгуулах, малдаа хүрэлцэхүйц хэмжээний өвс, тэжээлийг бэлтгэж, нөөцлөх, худаг уст цэгийн эзэмшилт, ашиглалт, хашаа хорооны хангамжийг сайжруулах, эр сувай малыг зах зээлд борлуулах, зам даваа хаагдаж болзошгүй газарт өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх, малчдын хувийн бэлтгэлийг сайтар хангуулах зэрэгт тодорхой чиглэл өгч ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд 2019 оны жилийн эцсийн мал тооллогоор 3.6 сая толгой мал тоологдож, өвөлжиж, хаваржсан бөгөөд 2020-2021 онд 3.5 сая мал өвөлжиж, хаваржихаар зохион байгуулагдаж байна.

Аймгийн хэмжээнд малчдын хүчээр 111.2 мянган тн байгалийн хадлан, 12.2 мянган тн тэжээл, 13.1 мянган тн давс хужир, шүү бэлтгэх төлөвлөгөөг сумдад хүргүүлж, бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Засгийн газрын 2020 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн “Хөдөө аж ахуйн салбарын 2020-2021 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” 19 дугаар тогтоолоор аймаг, сумын аюулгүйн нөөцийн өвс, тэжээлийн хэмжээ өөрчлөгдсөн.

Тухайлбал: Аймаг 770 тн өвс, 150 тн тэжээл, сумд 100 тн өвс, 40 тн тэжээл бэлтгэхээр байна.

Аймгийн хэмжээнд хадлан бэлтгэлийн ажилд дугуйт трактор 168, трактор хадуур 76, трактор тармуур 63, хаман боогч 37, гар хадуур 1501, бага оврын трактор хадуур 1136, хүн хүч 4704 ажиллах тооцоо судалгааг гаргаад байна.

Тэшиг, Хутаг-Өндөр, Сэлэнгэ, Хангал, Бугат сумдын хадлан бэлтгэлийн ажил 8 дугаар сарын 15-наас эхэлнэ.

Рашаант, Баяннуур, Гурванбулаг, Дашинчилэн, Могод, Хишиг-Өндөр сумдад хадлан бэлтгэх боломжгүй, малын тарга хүч тааруу байна.

Иймээс хадлангийн ургац муу байгаа Рашаант, Баяннуур, Гурванбулаг, Дашинчилэн, Могод, Хишиг-Өндөр сумын малчдын хэрэгцээт өвсийг Сэлэнгэ, Бугат, Хангал, Тэшиг, Хутаг-Өндөр сумаас, бусад 10 сумыг өөрсдийн хэрэгцээт хадланг бэлтгэх зохион байгуулалт хийж байна.

Хадлан бэлтгэх боломжтой газар нутаг ялангуяа улсын тусгай хамгаалалттай газрын хадлангийн ургацыг үзэж, зохион байгуулалтын арга хэмжээ авах шаардлагатай байна.

Монгол улсын Засгийн газрын 286 дугаар тогтоолын дагуу Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнд 2020-2021 оны өвөл, хаврын бэлчээрийн даацыг баг бүрийн бэлчээрийн ургац, малын тоо, бэлчээрийн талбайн хэмжээ, бэлчээр ашиглах хугацаа зэрэг мэдээлэл дээр үндэслэн тооцоолж гаргасан байна.

Үүнээс үзэхэд зуншлагын байдал 2020 оны 8 дугаар сарын 20-ны байдлаар нийт нутгийн 90 гаруй хувьд хэвийн сайн, 10 орчим хувьд дунд зэрэг гэсэн үнэлгээтэй байна.

Бэлчээрийн даацыг тооцоолж гаргасан дүнгээс үзвэл нийт нутгийн:

31% - 50 хүртэлх хувь (бэлчээрийн нөөцтэй)

23% - 51-100 хувь (бэлчээр хүрэлцээтэй)

36% - 101-300 хувь (даац 1-3 дахин хэтэрсэн)

4% - 301-500 хувь (даац 3-5 дахин хэтэрсэн)

6% - 500 хувиас их (даац олон дахин хэтэрсэн) байна.

Өөрөөр хэлбэл нийт нутгийн 50 гаруй хувьд нь өвөл-хаврын бэлчээрийн даац хүрэлцээтэй байхаар, харин 50 орчим хувьд хэтэрч гарчээ.

Энэ зун нутгийн өмнөд хагаст бороо хур багатай, зуншлага дунд байсан ба 7 дугаар сарын дундуур ургамлын ургалт дээрдэж байна. Зуншлага сайн байсан нутгаар даац хэтэрч гарсан нь малын тоо их байгаатай холбоотой.

Сумын дүнгээр авч үзвэл Рашаант, Баяннуур, Гурванбулаг, Могод, Хангал сумын ихэнх нутгаар, Сэлэнгэ, Хутаг, Баян-Агт, Орхон, Хишиг-Өндөр сумын зарим багийн нутгаар даац хэтэрч гарсан байна.

Бэлчээрийн даац олон дахин хэтэрч (улаан) гарсан сумдад Рашаант, Гурванбулаг, Баяннуур, Сайхан сумд орж байна.

Нийт нутгийн 36% нь бэлчээрийн даац 1-3 дахин хэтэрч (шар) гарсан нутагт хамрагдаж байна.

Өвөл-хаврын бэлчээрийн даац ихээхэн хэтэрч гарсан сумдын нутагт өвс хадлан бэлтгэх, нэмэгдэл тэжээл нөөцлөх, отор нүүдэл хийх, мал сүргийг эдийн засгийн эргэлтэд оруулах зэрэг арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

Хүнс, газар тариалангийн талаар:

Аймгийн дүнгээр үр тариа 38264 га талбайгаас 51360 тн, буудай 37350 га-аас 50187 тн, малын тэжээл 2650 гаас 4040 тн, тосны ургамал 4887 га аас 2644 тн, төмс 552 га аас 5256 тн хүнсний ногоо 156 га аас 2000 тн-ыг хураан авах баланс гарсан. Ургацын балансыг нэгтгэж яаманд хүргүүлэв.

17-19 нд Дархан-Уул аймагт “Жимс жимсгэнийн суулгац үржүүлэгт баталгаа хийх аргазүйн сургалтад хамрагдаж, сертификат авсан.

20-28 ны өдрүүдэд Хутаг-Өндөр, Тэшиг, Сэлэнгэ, Хангал, Бугат суманд ургац тогтоох, ургац хураалтын бэлтгэл ажлыг шалгах удирдамжаар ажилласан. Бусад сумдын ургацын урьдчилсан балансыг урд сумдад ажилласан ажлын хэсгийн дүнгээр авч нэгтгэсэн.

Мал эмнэлгийн чиглэлээр:

Гамшгийн бэлэн байдлыг хангах чиглэлээр:

Мал эмнэлгийн газрын нийт ажилтнууд өндөржүүлсэн бэлэн байдлыг ханган, Мал эмнэлгийн Ерөнхий газар, аймгийн ОК, ОБГ-ын шуурхай штабтай холбогдон мэдээллийг цаг тухай бүрд хүргэн, мэргэжилтнүүдэд 2020 оны 8 сарын 30 хүртэл шинэчилсэн хуваарийн дагуу шуурхай жижүүрийн үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна.

Коронавирус /COVID-19/-т халдвараас урьдчилан сэргийлэх ажилд анхаарч халдвар, хамгааллын дэглэмийг баримталж, байгууллагын цэвэрлэгээ, үйлчилгээг сайжруулж, гаднаас ирж байгаа хүмүүсийг бүртгэн, халууныг хэмжиж, болзошгүй эрсдэлээс хамгаалах ажлыг зохион байгуулж байна. “Цэвэр-орчин, Цэмцгэр-Булган” аяны хүрээнд байгууллагын ойр орчмын 50 метр газрын цэвэрлэгээ, Мал эмнэлгийн лабораторийн хашаа, орчны бохирдлыг цэвэрлэж, хог, хаягдлыг зайлуулсан.

Мал эмнэлгийн лабораторийн шинжилгээний ажлын талаар:

Нян судлалын шинжилгээ: Мал амьтны өвчний онош тогтоох шинжилгээнд Могод, Орхон, Баян-Агт, Сайхан сумдаас нийт 24 дээж ирж шинжилгээнд хамрагдлаа. Баян-Агт, Орхон суманд үхэрт галзуу өвчин оношлогдсон.

Ийлдэс судлалын шинжилгээ: Ийлдэс судлалын шинжилгээнд адууны нийлүүлгийн өвчин, бог малын мялзан өвчин, бруцеллёз өвчний тандалт шинжилгээ хийгдлээ. Нийт 251 дээж ирж шинжилгээнд хамрагдсан байна. Бог малын мялзан өвчний халдварын байдлыг тандах өвчингүй тайван бүс болохыг нотлох тандалтыг ажлыг Орхон сумын Бүхт, Майнт багт хийсэн. Энэ шинжилгээнд 10 өрхийн хонь 120, ямаа 120 нийт 240 бог малаас цус аван ийлдсийг стандарт арга зүйн дагуу авч шинжилгээнд бэлтгээд байна.

Ариун цэврийн шинжилгээнд: Нийт 89 дээж ирсэн. Шинжилгээний дүнг гарган хариуг олгон ажиллаа. Үүнд: Махны дээж 60 айрагны 2 сүүний 27 дээж хамрагдсан байна.

Зургаа: Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын чиглэлээр:

Байгаль орчны чиглэлээр:

Тэшиг сумын нутаг дэвсгэрт хэрэгжих “Ингэт өлзийт” ХХК-ийн Зүсмэл материал үйлдвэрлэх төсөл, Орхон сумын нутаг дэвсгэрт хэрэгжих “Галил” ШБ-ийн “Сүмийн сургалтын үйл ажиллагаа явуулах” төслийн 2020 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулсан.

Тус сумдын нутаг дэвсгэрт олгогдсон 49 тусгай зөвшөөрөлтэй талбайн олборлолтын улмаас эвдэрсэн газрын судалгааг хийж Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газарт хүргүүллээ.

Бугат сумын 1-р багийн нутаг дэвсгэрт хэрэгжих “Зүсмэл материал үйлдвэрлэх” төсөлд байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлээ.

Нүд мод ХХК-ийн Хутаг-Өндөр сумын Уньт баг, Бугат сумын 1-р багийн нутаг дэвсгэрт хэрэгжих “Зүсмэл материал үйлдвэрлэх төсөл”, Ингэт өлзийт ХХК-ийн Сэлэнгэ сумын Сэлэнгэбүрэн сумын нутаг дэвсгэрт хэрэгжих “Зүсмэл материал үйлдвэрлэх төсөл”-ийн 2020 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлууллаа.

Эрхт түшиг ХХК-ийн Могод сумын 5-р багийн нутаг дэвсгэрт хэрэгжиж байгаа “Шатахуун түгээх станц”-ын төсөлд байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлээ.

Тэшиг, Орхон, Хангал, Бугат сумдад ойжуулалт, ойн хортны тэмцлийн гэрлэн урих тавих ажилд хяналт тавин ажиллаа. Мөн Рашаант, Бугат сумын ойжуулалтын ургалтын явцыг шалгалаа.

Аймгийн Засаг даргын 2020 оны 08 сарын 03-ны өдрийн А/336 дугаар захирамжийг батлуулсан.

Бэлсэг ХХК-ийн Хангал сумын Хялганат 4-р баг, Өндөр хужирт ХХК-ийн Хангал сумын 3-р багийн нутаг дэвсгэрт тус тус хэрэгжиж байгаа “Зүсмэл материал үйлдвэрлэх төсөл”-ийн 2020 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлууллаа.

Бэлсэг ХХК-ийн Хангал сумын Хялганат 4-р багийн нутаг дэвсгэрт хэрэгжиж байгаа “Зүсмэл материал үйлдвэрлэх” төсөлд байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлээ.

Аймгийн Засаг даргын 2020 оны 08 сарын 03-ны өдрийн А/336 дугаар захирамжаар батлагдсан ажлын хэсэг 8 дугаар сарын 12-ны өдөр 7 карьерын нөхөн сэргээлтийн ажлыг хүлээн авлаа.

Цагдаагийн Ерөнхий Газрын Экологийн цагдаагийн албанаас агаар, ус хөрсний бохирдлоос урьдчилан сэргийлэх, аялал жуулчлалын улмаас хүрээлэн байгаа орчинд үүсэж байгаа сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Аялал жуулчлалын бодлого, зохицуулалтын газартай хамтран байгаль орчноо хайрлан хамгаалах, эх оронч үзлийг түгээн дэлгэрүүлэх, иргэдийн буруу дадал хандлагыг өөрчлөх, эерэг соёлыг төлөвшүүлэх, зөв үйлдэлд уриалах зорилготой “ Байгаль эн тэргүүнд-Ирлээ, явлаа-цэвэр” нөлөөллийн арга хэмжээний хүрээнд Булган аймгийн Цагдаагийн газартай хамтран хяналт шалгалтыг зохион байгуулан ажиллаа.

Монгол улс “Хөхүүрийн айраг исгэх уламжлал, холбогдох зан үйл”-ийг ЮНЕСКО-ийн Хүн төрөлхтний соёлын биет бус өвийн жагсаалтад бүртгэн авснаас хойш зохиогдож буй анхны Айрагны баяр 08-р сарын 22-ны өдөр Булган аймгийн Сайхан сумын нутаг Өрмийн нуурын дэргэд зохион байгуулагдаж, тус арга хэмжээнд БОАЖ-ын сайд Д.Сарангэрэл, УИХ-ын гишүүн Ц.Анандбазар, АНУ-ын элчин сайд Майкл С. Клечески нарын төлөөлөгчид оролцлоо. Айрагны баяраар Адуучин, Хос морьтон шалгаруулах, Шагайн харваа, Сайхан айраг шалгаруулах, Дэмбээдэх, Хуруудах, Айраг хэн сайн уух вэ? зэрэг уралдаан тэмцээнүүд зохион байгуулагдлаа. Айрагны баярын арга хэмжээнд Булган аймгийн 16 сумын малчид, иргэд оролцож айраг, цагаан идээ худалдан борлууллаа.

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын чиглэлээр:

Булган аймгийн төв суурингийн өвөлжилтийн бэлтгэл хангах 2020-2021 оны ажлын төлөвлөгөө, Аймгийн Засаг даргын 2020 оны 08 дугаар сарын 24-ний өдөр баталсан “Мал аж ахуйн болон төв суурингийн өвөлжилтийн бэлтгэл ажлыг шалгах, сумдад ажиллах ажлын хэсгийн удирдамж”-ийн дагуу Бүрэгхангай, Могод, Орхон, Хишиг-Өндөр сумдад ажиллав.

Газар зохион байгуулалтын чиглэлээр

Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.2 дахь заалтын дагуу сумын Засаг дарга тухайн жилд иргэдэд өмчлүүлэх газрын байршил, нийт хэмжээний тухай саналыг хуульд заасан зориулалт тус бүрээр боловсруулж Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн аймаг, нийслэлийн Засаг даргад саналыг хүргүүлэхээр хуульчлагдсан. Иймд 2021 онд иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтын саналыг боловсруулан сумын ИТХ-

раа хэлэлцүүлэн аймгийн Засаг даргад уламжилсан тогтоол, хавсралтын хамт ирүүлэх талаар сумдын Засаг дарга нарт 01/886 дугаар албан тоотоор хүргүүлэв.

Геодези, зураг зүйн чиглэлээр

Баяннуур, Бүрэгхангай, Могод, Рашаант сумдын газар зүйн нэрийн тодруулалт, нэрийн мэдээллийн сан бүрдүүлэх ажлын гүйцэтгэгч “Инженер геодези” ХХК-иас ирүүлсэн гүйцэтгэлийн явцын тайланг үндэслэн нийт төсөвт өртгийн 70 хүртэлх хувиар санхүүжилтийг олгохоор аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэст 2020 оны 01/855 тоот албан бичгийг хүргүүлэн ажилласан.

Газар зүйн нэрийн тодруулалт, нэрийн мэдээллийн сан бүрдүүлэх ажлын даалгаварт тусгагдсаны дагуу нэр бүхий 7 суманд газар зүйн нэрийг ажлыг 09 дүгээр сард багтаан ИТХ-аар хэлэлцүүлэн холбогдох шийдвэрийг гаргуулан ирүүлэх тухай 01/842, 01/843 дугаар албан тоот бичгийг сумдын Засаг дарга нарт хүргүүллээ.

Газрын кадастрын хэмжилтийг нийт 15 нэгж талбар, үл хөдлөх эд хөрөнгөнд хийж гүйцэтгэснээс 7 иргэн, хуулийн этгээд газар болон үл хөдлөх эд хөрөнгийн зураглалыг мэдээллийн санд оруулж ажилласан. Дээрх үйл ажиллагаанаас 165892 төгрөгийг төрийн сангийн 100040029002 дансанд төвлөрүүлсэн.

Газрын суурь судалгаа, мониторингийн чиглэлээр

Парисын хэлэлцээрийн хүрээнд МУ-ын оруулах Үндэсний хувь нэмрийн (NDC) хэрэгжилтийг хөдөө аж ахуй, газар ашиглалтын салбарт илт тод байдлаар тайлагнах, мониторингийн үндэсний чадавхыг бэхжүүлэх Төслийн хүрээнд аймгийн хэмжээнд нийт 4918 цэгт газар ашиглалт, газар ашиглалтын өөрчлөлтийн үнэлгээг оруулахаар болсны дагуу төлөвлөгөө гарган нийт 4918 цэгийн үнэлгээг хийн тайланг Газрын даргын 2020 оны 08-р сарын 31-ны өдрийн 01/877 албан тоотоор хүргүүлэн ажилласан.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2020 оны А/131 дугаар тушаалаар батлагдсан “Газрын мониторингийн системийг ажлуулах журам”-ын 6.1.4-т заасны дагуу газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажлыг цахим хэлбэрээр хянаж байнгын шинжээчээр баталгаажуулахад орон нутгийн албан хаагчдад “Газрын мониторингийн систем”-ийн хэрэглэгчийн төвшний ур чадвар олгож, мэргэшүүлэх цахим сургалтад хамрагдсан.

Швейцарийн хөгжлийн агентлаг Ногоон алт – Малын эрүүл мэнд төсөлтэй хамтран “Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фотомониторингийн аргаар үнэлэх ажлыг улсын хэмжээнд 5 дахь жилдээ хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд энэ жилийн хувьд ГЗБГЗЗГ-с уралдаан зарласантай холбогдуулан сумдын газрын даамлуудад заавар зөвлөмж өгч ажиллаа.

2020 онд фотомониторингийн ажлыг хугацаанд нь хийх, тайлан мэдээг ирүүлэх талаар Газрын даргын 01/717 тоот хугацаатай албан бичгийг сумдад хүргүүлэн ажилласан 8-р сарын эхний 7 хоногт сумд хээрийн судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн одоогоор боловсруулалтын ажил хийгдэж байна.

Газрын кадастрын чиглэлээр

ГЗБГЗЗГ-ын даргын 2020 оны А/205 дугаар тушаалаар Газрын кадастрын мэдээллийн сангийн “Лэнд менежер” програм хангамжид нөхөн бүрдүүлэлт хийх эрхийг хааж байгаа тул 2020 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө мэдээллийн санд байгаа ажлын нэгж талбаруудыг иргэн, хуулийн этгээдтэй холбох арга хэмжээг авч хэрэгжүүлэх, мөн газрын кадастрын мэдээллийн санд нөхөн бүрдүүлэх шаардлагатай нэгж талбаруудын зурган болон хүснэгтэн мэдээллийг ГЗБГЗЗГ-ын даргын 2020 оны 1/2474 албан бичгийн хавсралтад заасан стандартын дагуу бэлтгэн 2020 оны 9 дүгээр сарын 4-ний өдрийн дотор ирүүлэх талаар сумдын Засаг дарга нарт 2020 оны 01/861 албан бичгээр сумдад хүргүүлээ.

Булган сумын 5 дугаар баг Д.Дамбын 1 дүгээр гудамж “Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв”-ийн хашааны баруун талд байршилтай автомашины гараашуудын зүүн талд 47 м²-аар 4 нэгж талбарыг автомашины гараашийн зориулалтаар, 6 дугаар баг Залуус 1 дүгээр гудамж “Долоон бар” ХХК-ийн баруун талд 2082 м² газрыг үйлдвэрлэлийн зориулалтаар тус тус дуудлага худалдаа явуулахаар төлөвлөж аймгийн Засаг даргаас санал авахаар 2020 оны 01/845 албан бичгийг хүргүүлээд байна.

Газар эзэмших эрх шилжүүлэхийг хүссэн 3 өргөдөл ирснээс аймгийн Засаг даргын 2020 оны А/339 дүгээр захирамжаар 1 иргэний автомашины гараашийн зориулалтаар эзэмшиж буй газрын газар эзэмших эрхийг шилжүүлж, 2 иргэний газар эзэмших эрхийг шилжүүлэх захирамжийн төслийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

2020 оны А/340 дүгээр автомашины засвар, үйлчилгээний зориулалтаар эзэмшиж буй 1 иргэний газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг 5 жилээр сунгалаа. Газар эзэмших эрхийн Э дугаар авахтай холбоотой 12 өргөдөл, хүсэлт ирүүлснийг шийдвэрлэн гэрээ, гэрчилгээг шинэчлэн олгоод байна.

Барилга, хот байгуулалтын чиглэлээр

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй Дашинчилэн сумын Эрүүл мэндийн төвийн барилгын засвар, Нэгдсэн эмнэлгийн ариутгалын тасгийн засвар, Орхон сумын “Ганга зайвар” ХХК-ын “Идэр” ШТС-ын барилга угсралтын ажил, “Булган нисэх буудлын” барилгын их засварын ажилд Монгол Улсын барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолоор баталсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн 3.1.4 дэх заалтын дагуу ГХБХБГ-ын даргын А/93, А/94, А/87, А/86 дугаар тушаалын дагуу комисс ажиллаж ашиглалтад орууллаа.

Булган аймгийн Бугат сумын “Жаргалант” хүүхдийн зуслангийн Захиргаа аж ахуйн барилга угсралтын ажил гүйцэтгэгч “Эрдэнэс эко үүр” ХХК нь барилга угсралтын ажлыг эхлүүлээ. Хангал сумын спорт заалын барилга угсралтын ажил гүйцэтгэгч “Анэрд” ХХК-ын ажлын явц 90%-тай авж байгаа бөгөөд 2020 оны 09 сарын 15-ны өдрөөс ашиглалтад өгөхөөр ажиллаж байна.

Булган сумын 3-р цэцэрлэгийн 75 хүүхдийн өргөтгөлийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгч “Виртуалсофт” ХХК 2020 оны 08 сарын 24-ны өдрөөс эхлүүлж. Гадна хашаа, мэдээлэх самбар, цахилгааны КТП суурилуулж байна.

“Булган аймагт үйл ажиллагаа эрхэлж буй барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллагуудын судалгааг” 2020 оны 08 сарын 19-ны өдрийн 01/840, мөн “Тана Орд” ХХК, “ХНЯ” ХХК, “Булган Мээж” ХХК, “Бүлээн-Оргил” ХХК, “Хурмастын хүлэг” ХХК, “Өвөлжөөн булаг” ХХК, “Долоон бар” ХХК, “Булган Барилга” ХХК, Цонхот” ХХК, “Нүнжигт өргөө” ХХК зэрэг 8 компанийн судалгааг гаргаж “МБҮА” ТББ-д хүргүүлэв.

Сумдын хөгжлийн хөтөлбөр боловсруулах ажлын хүрээнд Булган сумын 16 сум, 1 тосгоны судалгааг 2020 оны 08 сарын 17-ны өдрийн 01/838 дугаар албан бичгээр Барилгын хөгжлийн төвд хүргүүлэн ажилласан.

Барилга байгууламжийн зураг төслийн талаар:

"Мал сүргийг хулгайн гэмт халдлагаас хамгаалах Монголын нийгэмлэг" НҮТББ-д мал сүргийг хулгайн гэмт халдлагаас сэргийлэх зорилгоор Булган аймгийн төвөөс гарсан улсын чанартай 3 чиглэлийн авто зам дагуу, болон төв оффисын гадаа байрлуулах самбарын байршлын тойм зураг 11,12,13,14 тоот дугаартай 4 ширхэг виз гаргасан.

“Энхий жаргал” ХХК-ны боловсруулсан Булган сумын Майдар голын эргийн бэхэлгээ, Диваажин сумын орчны тохижилтын зураг төслийг хянаж үзээд 5 ширхэг санал, чиглэл өгч ажилласан.

БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР